МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024. 05. 10 № А-1/1974

танай ______________-ны № ______________-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас 2023 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр зарласан БШУЯ/202412119 дугаартай "XIII.1.1.370 Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Мөрөн сум, 8 дугаар цэцэрлэг/" төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

| Тодруулга | Хариулт |
|---|---|
| Ижил төстэй ажилд хийж гүйцэтгэж буй 75 хувийн гүйцэтгэлтэй 2024 онд дуусгахаар ажиллаж буй барилгын ажлыг тооцох эсэх талаар тодруулга гаргаж өгнө үү. | Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: Шаардана.<br>Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр ажилласан байна. Энэ шалгуурыг дараахаас аль нэгээр хянан үзнэ. Үүнд:<br>а)батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил.<br>б) барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний үнийн дүнг харгалзахгүйгээр тухайн ажлын хүчин чадал, барилгын ажлын нийт талбайн хэмжээний 30 болон түүнээс дээш хувь буюу 368.64 м2 бүхий талбайтай дүйцэхүйц ижил төстэй ажил.<br>ТШЗ 19.2-д Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:<br>а)Гэрээний үнийн дүнгээр тооцуулах ижил төстэй ажлын туршлагын шаардлагын хувьд: Ажил гүйцэтгэсэн гэрээ, Барилгын тухай хуульд заасан эрх бүхий байгууллагын ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлтийг ирүүлнэ.<br>б)Хүчин чадал, барилгын талбайн хэмжээгээр тооцуулах ижил төстэй ажлын туршлагын шаардлагын хувьд: Ажил гүйцэтгэсэн гэрээ, Барилгын тухай хуульд заасан эрх бүхий байгууллагын ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлт, тухайн барилгын магадлалын нэгдсэн дүгнэлтийг тус тус ирүүлнэ гэж заасны дагуу тооцно. |

ДАРГА Ц.БАТЗУЛ

9020020105 СБТ 11261 6529909

1324025334